

## “ЦАХИМ ЗАСАГЛАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Ерөнхий мэдээлэл

Төрийн үйл ажиллагааг боловсронгуй болгох түүнд инновацийг нэвтрүүлэх аргачлалуудын нэг нь цахим засаглалыг хөгжүүлэх явдал гэж үздэг. Дэлхийн улс оронд үйлдвэрлэлийн эринээс технологийн эринд шилжих үйл явц хурдацтай өрнөж мэдлэгт суурилсан эдийн засагт шилжиж байна. Төрийн захиргааны шинэчлэл нь төрийн байгууллага, иргэн, хувийн хэвшил, нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага зэрэг чухал сонирхогч талуудтай харилцах харилцааг боловсронгуй болгох, сайжруулахад мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд оршино.

Монгол Улс 2005 оноос эхлэн цахим засгийн бодлогыг тодорхойлох зорилгоор “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”, “Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”, “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

“Бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд иргэдэд цахим иргэний үнэмлэх олгох, Үндэсний дата төвийг байгуулах, иргэн, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэл зэрэг ажлуудыг хийж цахим засаглалын хөгжилд дэх түүхэн үүргээ гүйцэтгэсэн юм. Мөн 2010 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн орон даяар иргэний шинэчилсэн бүртгэл эхлүүлж, 21 аймгийн 331 сум, 9 дүүргийн 132 хороо буюу нийт 463 нэгжээр дамжуулан бүртгэлд хамруулж, анхны цахим сонгуулиа хийсэн.

Цахим засаг үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн мэдээлэл солилцооны харилцан холболтын дэд бүтцийг байгуулах судалгааг хийж, судалгаанд 63 төрийн байгууллага хамрагдсан. Эдгээрээс 50 байгууллага нь цахим мэдээллийн сантай бусад 13 байгууллагад цахим мэдээллийн сан үүсээгүй мэдээллийг цаасан хэлбэрээр цуглуулдаг байна. Үүнээс цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээг тодорхойлж 25 үйлчилгээг Төрийн үйлчилгээний цахим машинаар, төрийн үйлчилгээний нэгдсэн портал болох [www.ezasag.mn](http://www.ezasag.mn) цахим хуудсаар иргэдийн зүгээс хамгийн их хүндрэл чирэгдэлтэй гэж үзсэн 18 үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд бэлэн болоод байна.

ТҮЦ машины үйлчилгээг нэвтрүүлснээр 2017 онд 1,5 сая иргэн давхардсан тоогоор үйлчлүүлж, иргэд нэг жилд 9 тэрбум төгрөг, нэг үйлчилгээ авахад 1 цаг 40 минут хэмнэж байна.

Цаашид хатуу болон зөөлөн дэд бүтцийг нэгдсэн бодлого төлөвлөлттэй зохион байгуулж төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нээлттэй өгөгдлийн сан үүсгэж хэрэглээг дэмжих, төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэх, хүний хөгжлийг дэмжиж ухаалаг төхөөрөмж ашиглан орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахим хэлбэрээр авах төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Мөн эдийн засаг, нийгмийн салбаруудад мэдээллийн технологийн дэвшлийг нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгээр нэвтрүүлж тунгалаг, өрсөлдөх чадвартай, өндөр бүтээмж бүхий хариуцлагатай төрийг бий болгох зорилгоор иргэн төвтэй цахим

засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Дээрх үндэслэл, шаардлагын хүрээнд “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Загийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2025” зэргийг тус тус үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр.Цахим засаглал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим,  
хамрах хүрээ, хугацаа

2.1. Цахим засаглал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлана. Үүнд:

2.1.1. хүний эрхийг дээдлэн хувь хүний өгөгдлийг хамгаалах;

2.1.2. ил тод, тунгалаг, иргэн төвтэй, хариуцлагатай, өндөр бүтээмжтэй засаглалыг эрхэмлэх;

2.1.3. төр, иргэн, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурласан, харилцан уялдаатай, нэгдмэл цогц байх;

2.1.4. мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан төрийн бодлого, үйл ажиллагаан дах иргэдийн оролцоог хангах;

2.1.5. цахим хэлбэрээр хүргэх төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд авах боломжтой байх;

2.1.6. хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлоготой байх;

2.1.7. төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байх;

2.1.8. ногоон технологийг дэмжих;

2.1.9. төрийн байгууллагын мэдээллийн систем нь төрийн мэдээлэл солилцооны системтэй холбогдох боломжтой байх.

2.2. Хөтөлбөрийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт төрийн байгууллага, иргэдийг хамруулж хэрэгжүүлнэ.

2.3. Цахим засаглал үндэсний хөтөлбөрийг 2019 – 2022 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

#### Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

3.1. Цахим засаглал үндэсний хөтөлбөрийн зорилго нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхижүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацийг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох замаар цахим засаглалыг хөгжүүлэхэд оршино.

3.2. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

3.2.1. бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох;

3.2.2. цахим засагийн хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэх;

3.2.3. цахим засгийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, хатуу болон зөөлөн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгээр хөгжүүлэх;

3.2.4. төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлэх;

3.2.5. иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжих;

3.2.6. цахим оролцоог хөгжүүлж, төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах;

3.2.7. мэдээллийн технологийн аудитын тогтолцоог бүрдүүлэх;

3.2.8. бүх шатны төрийн байгууллага, албан хаагчдад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх;

3.2.9. монгол хүний хөгжлийг дэмжиж, эдийн засаг, нийгмийн бүх салбаруудад мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх замаар хөгжлийг хурдасган, бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

4.1. Бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох **нэг дүгээр зорилтын хүрээнд** дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон зорилтот бүлгүүдийн нийгэмд эзлэх тэгш оролцоог бүрдүүлэх зорилгоор тусгай техник, програм хангамж нэвтрүүлэх болон төрөл бүрийн контентоор хангах;

4.1.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон зорилтот бүлэгт зориулсан мэдээлэл, харилцаа холбооны технологийн талаар боловсрол олгох төрөл бүрийн сургалтын танхимууд байгуулж, сургалт зохион байгууулах;

4.1.3. төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр орон нутгийн иргэд, малчид, ахмад настангуудад энгийн, хялбар програм хангамжийг хөгжүүлж, нэвтрүүлэх;

4.1.4. радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн нийтэд хүртээмжтэй давуу талыг ашиглан хувь хүний хөгжил, мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн, үр өгөөж бүхий төрөлжсөн контентуудыг бүтээх, түгээх;

4.1.5. төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, хот, орон нутгийн тоон бичиг үсгийн ялгааг багасган орон нутгийн интернэтийн хурдыг нэмэгдүүлэх;

4.1.6. бүх шатны боловсролын сургуулийн удирдлага, үйл ажиллагаа, статистик мэдээ, мэдээллийг нэгтгэх системийг боловсруулж нэвтрүүлэх, ашиглах;

4.1.7. интернэт болон өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулан бүх нийтэд алсын зайн сургалтуудыг тогтмол зохион байгуулах;

4.1.8. бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн суурь мэдлэг чадварыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэн бүх шатны сургууль болон бусад сургалтын байгууллагуудад мэдээлэл, харилцаа холбооны технологийн ур чадвар олгох, суурь сургалтуудыг зохион байгуулах;

4.1.9. мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх бодлогын баримтлах чиглэл боловсруулж батлуулах, мэргэшлийн чадавхийг сайжруулах сургалт болон үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;

4.1.10. мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр боловсрол олгож байгаа бүх шатны сургууль болон сургалтын байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах.

4.2. Цахим засгийн хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэх **хоёр дугаар зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.2.1. цахим засгийн хуулийг шинээр боловсруулж батлуулах, холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах;

4.2.2. өгөгдөл хамгаалах тухай хуулийг шинээр боловсруулан батлуулах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;

4.2.3. өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй тоног төхөөрөмж болон олон нийтэд хүртээмжтэй цахим хуудасны стандарт боловсруулах;

4.2.4. мэдээллийн технологийн чиглэлийн стандартын бодлогын чиглэл боловсруулж, батлуулах;

4.2.5. цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах стандарт, тогтоомж боловсруулан батлуулах.

4.3. Цахим засгийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, хатуу болон зөөлөн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгээр хөгжүүлэх **гурав дугаар зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.3.1. цахим засаглалыг хөгжүүлэх удирдлагын тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

4.3.2. төрийн мэдээлэл солилцох үүлэн тооцооллын дэд бүтцийг өргөтгөх;

4.3.3. төрийн мэдээлэл солилцооны системийг сайжруулан хөгжүүлэх;

4.3.4. цахим төлбөр тооцооны нэгдсэн системийг төрийн мэдээлэл солилцооны системтэй холбох;

4.3.5. төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх бизнес процессийн ре-инженеринг хийх;

4.3.6. төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх цахим нэг цонхны үйлчилгээ бий болгох;

4.3.7. төрийн үйлчилгээний нэгдсэн портал сайтыг боловсронгуй болгох;

4.3.8. төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас хөдөлгөөнт холбооны технологи ашиглан үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх;

4.3.9. төрөөс цахим хэлбэрээр иргэнд хүргэх үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх;

4.3.10. үүрэн холбооны дугаараар иргэн таних боломжтой болох;

4.3.11. төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх;

4.3.12. захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлт болон солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хэвшүүлэх;

4.3.13. Үндэсний дата төвийн нөөц төвийг байгуулах.

4.4. Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлэх **дөрөв дүгээр зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.4.1. Үндэсний дата төвийн үүлэн тооцооллын системд нэгдсэн ангилал кодчиллын мэдээллийн сан үүсгэж, суурь болон төрөлжсөн мэдээлэл бүрдүүлэгч төрийн байгууллагуудын системүүдтэй холбох;

4.4.2. хувь хүний өгөгдөлд хандсан тухай мэдээлэл иргэнд хүрэх боломжийг бүрдүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх;

4.4.3. төрийн мэдээллийн нээлттэй өгөгдлийн бодлогын чиглэл боловсруулж, батлуулах;

4.4.4. төрийн мэдээллийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал хөгжүүлэх;

4.4.5. төрийн мэдээллийн нээлттэй өгөгдлийн сан үүсгэх, ашиглах журам боловсруулах;

4.4.6. газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтийн нэгдсэн сан бүрдүүлэх, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлэх;

4.4.7. Үндэсний дата төвийн мэдээллийн систем, сүлжээ, өгөгдлийн сангийн хамгаалалтыг сайжруулах, шинэчлэх.

4.5. Иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжих **тав дугаар зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.5.1. төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг концессоор хэрэгжүүлэх;

4.5.2. иргэдэд тоон гарын үсэг олгож, эдийн засаг, нийгмийн харилцаанд нэвтрүүлэх;

4.5.3. програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын зах зээлийн судалгааг жил бүр хийх;

4.5.4. төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн ажил үйлчилгээг аутсорсингоор үе шаттайгаар хэрэгжүүлэх;

4.5.5. төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг боловсронгуй болгох, инноваци нэвтрүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

4.6. Цахим оролцоог хөгжүүлж, төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах **зургаа дугаар зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.6.1. иргэдийн оролцоо, санал санаачлага, өргөдөл, гомдлыг нэгтгэх, төрийн бодлого, шийдвэр гаргалтад тусгах боломжийг бүрдүүлэх, бизнес анализийн систем хөгжүүлэх;

4.6.2. төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлэг хийх системийг сайжруулан хөгжүүлэх;

4.6.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрийн үйлчилгээ, үйл ажиллггааны талаарх мэдээллийн хүртээмжтэй байдлыг сайжруулах, оролцоог хангах систем хөгжүүлж, нэвтрүүлэх.

4.7. Мэдээллийн технологийн аудитын тогтолцоог бүрдүүлэх **долоо дугаар зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.7.1. мэдээллийн технологийн аудитын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

4.7.2. мэдээллийн технологийн аудитын нөхцөл шаардлагыг тодорхойлон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификатыг нутагшуулах;

4.7.3. мэдээллийн технологийн аудитын хүний нөөцийг хөгжүүлэх;

4.7.4. мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах сорилтын лаборатори байгуулах.

4.8. бүх шатны төрийн байгууллага, албан хаагчдад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх **найм дугаар зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.8.1. бүх шатны төрийн байгууллага, албан хаагчдын нийгмийн мэдээллийн сүлжээ болон интернэт орчны ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх удирдамж, зөвлөмжөөр хангах;

4.8.2. нийгмийн мэдээллийн сүлжээний зохистой хэрэглээг дэмжих журам боловсруулах;

4.8.3. бүх шатны төрийн байгууллага, албан хаагчдын дунд нийгмийн мэдээллийн сүлжээний зохистой хэрэглээний талаар сургалт зохион байгуулах;

4.8.4. төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлэх, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;

4.8.5. төрийн байгууллагын бүх шатны албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх гарын авлага боловсруулж түгээх, сургалт зохион байгуулах.

4.9. Монгол хүний хөгжлийг дэмжиж, эдийн засаг, нийгмийн бүх салбаруудад мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх замаар хөгжлийг хурдасган, бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх **ес дүгээр зорилтын хүрээнд** дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.9.1. мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл байгуулах;

4.9.2. мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөлийн үйл ажиллагаанд салбар дундын тулгамдсан асуудлыг тусгаж шийдвэрлэх;

4.9.3. мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр давхардсан, үр ашиггүй хөрөнгө оруулалтыг арилгах, нэгдсэн бодлого, удирдлагаар хангах;

4.9.4. эдийн засаг, нийгмийн мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах;

4.9.5. төрийн мэдээлэл солилцооны системд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын системийг холбох;



4.9.6. эдийн засаг, нийгмийн салбарт мэдээллийн технологийн дэвшил, төрийн үйл ажиллагаанд инновацийг нэвтрүүлэх үйл ажиллагааг хариуцсан бодлогын болон техникийн албан хаагчдыг томилж, тогтмол хамтын ажиллагааг хангах.

Тав. Хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийг 2016 оны түвшин, үзүүлэлттэй харьцуулан хүрэх үр дүнг хэмжинэ.

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтод түвшин	Мэдээллийн эх сурвалж
1	Бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох	Иргэдийн тоон бичиг үсгийн чадавхи	%	32	80	БНҮҮС-ийн судалгаа
2	Цахим засгийн хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэх	Цахим засгийн тухай болон Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барих	Хуультай эсэх	Байхгүй	Хуультай болно	ХХМТГ
3	Цахим засгийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, хатуу болон зөөлөн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгээр хөгжүүлэх	Цахим үйлчилгээний индекс	Индексийн үзүүлэлт	0.597	0.65	НҮБ цахим засгийн хөгжлийн санал асуулга
4	Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлэх	Төрийн мэдээлэл солилцооны системд бүртгэлтэй үйлчилгээний тоо	Тоо	25	176	Бодлогын судалгаа
5	Иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжих	Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээр гүйцэтгүүлж байгаа үйлчилгээний тоо	тоо	0	100	Бодлогын судалгаа
6	Цахим оролцоог хөгжүүлж, төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах	Цахим оролцооны индекс	Индексийн үзүүлэлт	0.73	0.76	НҮБ цахим засгийн хөгжлийн санал асуулга
7	Мэдээллийн технологийн аудитын тогтолцоог бүрдүүлэх	Мэдээллийн технологийн аудитын үйлчилгээ эрхлэгч	тоо	4	10	Бодлогын судалгаа
8	Бүх шатны төрийн байгууллага, албан	Сургалтанд хамрагдсан албан хаагчид	тоо	400	2000	Бодлогын судалгаа

	хаагчдад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх					
9	Монгол хүний хөгжлийг дэмжиж, эдийн засаг, нийгмийн бүх салбаруудад мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх замаар хөгжлийг хурдасган, бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт	%	0	100	Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл
10	Цахим засаглалын хөгжил	Цахим засгийн хөгжлийн индекс	тоо	0.582	0.6	НҮБ цахим засгийн хөгжлийн санал асуулга

### Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Цахим засаглал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана.

6.2. Цахим засаглал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

- 6.2.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.2.2. гадаадын зээл тусламж;
- 6.2.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 6.2.4. концессын гэрээ;
- 6.2.5. бусад эх үүсвэр.

### Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

7.1. Харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь жил бүр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулна.

7.2. Харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүрийн нэг дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, тогтоолд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.4. Хөтөлбөрийн явцын болон үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах үндэслэл болно.

~ о О о ~